



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 11 өдөр

Дугаар АБ57

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 134
дүгээр сургуулийн балансаас
хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 129,201,492.0 /нэг зуун хорин есөн сая хоёр зуун нэг мянга дөрвөн зуун ерэн хоёр/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлж данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 134 дүгээр сургууль /Б.Нарангэрэл/-д зөвшөөрсүгэй.


2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ /Г.Баттулга/-т үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 134 дүгээр сургууль /Б.Нарангэрэл/-д, "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ Г.Баттулга/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /С.Ариунжаргал/-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001093

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 10 сарын
 11 өдрийн 11354 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 134 дүгээр сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар үзүүлэлт	Ашиглалтанд орсон	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Шилжүүлэн авах байгууллага
1	Халаалтын зуух	KCR-240 0,3 МВт	2016	ш	2	42,000,000.00	84,000,000.00	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ
2	Халуун усны халаагч бойлер		2016	ш	2	8,087,178.00	16,174,356.00	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ
3	Дизель станц /цахилгаан үүсгүүр/	10 кВт	2016	ш	1	12,500,000.00	12,500,000.00	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ
4	Гадна дулааны шугам		2016	м	21	9,979,920.00	9,979,920.00	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ
5	Гадна дулааны худаг		2016	ш	1	6,547,216.00	6,547,216.00	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ
Нийт тоног төхөөрөмж, хөрөнгийн дүн							129,201,492.00	